



ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ



ТАТВАРЫН ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ

2006 оноос хойш эдийн засаг, бизнесийн харилцаа өргөжин төрөлжиж, даяарчлагдсан нарийн төвөгтэй, техник технологийн хурдацтай өөрчлөлтийн орчинд явагдаж байна.

Дэлхийн түвшний үндэстэн дамнасан корпорациуд манай улсад үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр корпорациуд улс хооронд үнэ шилжилт хийн татвараас зайлсхийх эрсдэл үүсч татварын маргаан, үл ойлголцол нэмэгдэж байна.

Татварын эрх зүйн орчин ил тод биш, мэдээлэл харилцан солилцдоггүй, үнэ шилжилт хийх боломжтой, татвараас зайлсхийх "гүүр" улс болох эрсдэлтэй тул Европын холбооны Хар жагсаалтад орсон.

Бизнес, эдийн засгийн хөгжлийн хурдац эрчимжиж, шинэ харилцаа, технологи өдөр тутмын амьдралд нэвтэрч буй даяарчлагдсан дэлхийд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн дэд бүтцийн нэг болох татварын хууль тогтоомжийг уялдуулан шинэчлэх шаардлага зүй ёсоор урган гарсан болно.



Татварын ачааллыг
бууруулна



Татварын тайлангийн
тоог цөөрүүлнэ

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ОРЧНЫГ ДЭМЖИХ

- Жилийн **50 сая** төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой, НӨАТ суутган төлөгч биш татвар төлөгч жилд **1 удаа** тайлан гаргаж, нийт борлуулалтын орлогын **1 хувиар** орлогын татвар төлөх хялбаршуулсан горимыг сонгон хэрэглэх боломжийг олгоно.
- Жилийн **300 сая** төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд жилд **2 удаа** тайлагнаж, татвар ногдуулах орлогын **1 хувиар** татвар төлнө.
- Жилийн **300 саяас 1.5 тэрбум** төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд жилд **2 удаа** тайлагнан татвар ногдуулах орлогын 10 хувиар татвар төлж, төлсөн татварын **90 хувийг** буцаан авна.
- 25 хувийн татвар төлөх босгыг 3 тэрбум төгрөг байсныг нэмэгдүүлэн **6 тэрбум** төгрөг болгосон.
- Татварын тайлангаар гарсан алдагдлыг салбар харгалзахгүйгээр **4 жилийн** хугацаанд шилжүүлэн тооцно.



Хөрөнгийн зах зээлийг
дэмжиж, зээлийн хүүг
бууруулна




Хяналт шалгалт хийх
хөөн хэлэлцэх
хугацааг бууруулна

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ОРЧНЫГ ДЭМЖИХ

- **Ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй**, Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан аж ахуйн нэгжийн дотоод, гадаадын анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл худалдан авсан хөрөнгө оруулагчийн **хүүгийн орлогод 5 хувийн** татвар ногдуулна.
- Монгол Улсын **арилжааны банкны** гадаад, дотоодын эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн зээл, өрийн хэрэгслийн **хүүгийн орлогод 5 хувийн** татвар ногдуулна.
- Татварын хяналт шалгалт хийх, нөхөн ногдуулалтын акт гаргах, алданги, торгууль ногдуулах **хөөн хэлэлцэх хугацаа** 5 жил байсныг **4 жил** болгон буурууллаа.
- **Ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй** аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацааг 40 жилээс **25 жил** болгон буурууллаа.



Иргэдийг орон
сууцжуулах бодлогыг
дэмжинэ



Алслагдсан орон
нутагт татварын
дэмжлэг үзүүлнэ.

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ОРЧНЫГ ДЭМЖИХ

- Амьдран суух зориулалтаар анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл худалдан авсан иргэнд 3 сая төгрөгийн татварын **хөнгөлөлт үзүүлдэг** байсныг **6 сая төгрөг** болгон нэмэгдүүллээ.
- **Ипотекийн зээлийн** хөрөнгөөр хувьдаа анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний **татварын хөнгөлөлт** эдлүүлнэ.
- Улаанбаатар хотоос 500 км-ээс дээш алслагдсан аймаг, суманд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, хувь хүний төлсөн үйл ажиллагааны орлогод ногдох татварыг **50 хувиар**, 1000 км-ээс дээш алслагдсан бол төлсөн татварыг **90 хувиар хөнгөлнө**.
- Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал, модны суулгац зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох татварыг **50 хувиар хөнгөлнө**.



Тайлан залруулах
боломжийг олгоно



Татварын өр төлөх
хугацааны хөнгөлөлт
үзүүлнэ

ТАТВАРЫГ ЭНГИЙН ХЯЛБАР БОЛГОХ

- Жилийн 6 тэрбум хүртэл төгрөгийн татвар ногдуулах орлоготой аж ахуйн нэгж жилд **2 удаа** тайлан гаргана.
- Хуульд заасан шалгуур хангасан **бүх төрлийн зардлыг** татвар ногдох орлогоос **хасаж тооцохыг** зөвшөөрнө.
- Ирүүлсэн татварын тайлангийн тоон мэдээлэл зөрүүтэй, алдаатай байвал татвар төлөгчид эргэн мэдэгдэж **3 хоногийн дотор залруулах** боломжийг олгоно.
- Татварын тайланг **1 жилийн дотор** аливаа **торгуульгүйгээр залруулах** боломжийг олгоно.
- Татварын албаны үндэслэлгүй хураасан илүү төлөлтийг **нэн тэргүүнд** алдангийн хамт буцаан олгоно.
- Хуульд заасан нөхцөл үүссэн, хүндрэлтэй татвар төлөгчийн өр төлөх хугацаа 2 сар хүртэл сунгадаг байсныг **2 жил хүртэл** болгон нэмэгдүүлсэн.
- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх олон нийтэд ил тод, нээлттэй нэгдсэн **зөвлөмжийг** гарган татварын байцаагчид хуулийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх боломжгүй болно.
- Татварын **хяналт шалгалтыг** бүх аж ахуйн нэгжүүдэд бус **зөвхөн эрсдэлтэй** гэж үнэлэгдсэн тохиолдолд хийнэ.



**Татварын алба илүү
хариуцлагатай болно**

ТАТВАРЫН АЛБА, БАЙЦААГЧДЫН ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛСЭН

Татварын улсын байцаагчийн үйлдсэн доор дурдсон зөрчилд **10 хүртэл жил эргэж орох эрхгүй хүртэл халах** Захиргааны шийтгэл оногдуулна.

- Гаргасан акт нь эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон
- Татварын ерөнхий хуулиар хамгаалагдсан татвар төлөгчийн мэдээллийн нууцыг задруулсан
- Хуульд заасан албан тушаалын эрхээ хэтрүүлсэн, эсхүл үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй.

Татварын улсын байцаагч дээр дурдсан зөрчлийн улмаас татвар төлөгчид хохирол учруулсан уг **хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцна.**

ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ БОЛОМЖИЙГ ХААЖ, ТАТВАРЫН СУУРИЙГ ХАМГААЛНА



Татварын суурийг
багасгах, ашиг
шилжүүлэхийн эсрэг
олон улсын дүрмүүдийг
нэвтрүүлнэ.



Татварын үйлчилгээг
цахимжуулна

- Татварын суурийг бууруулах, ашиг шилжүүлэхийн эсрэг “**BEPS**”-ийн дүрэм журмуудыг хэрэгжүүлж татвараас зайлсхийх эрсдлийг бууруулна.
- Олон улсын стандартад нийцсэн **үнэ шилжилтийн** эсрэг дүрэм журмуудыг нэвтрүүлэн татварын бааз суурийг хамгаална.
- Татварын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж татварын **үйлчилгээг бүрэн цахимжуулна.**
- Татварын зорилгоор дэлхийн 190 гаруй улстай **мэдээлэл харилцан солилцоно.**


ӨВ ЗАЛГАМЖЛАГЧИД ТАТВАРЫН ӨР ШИЛЖИХ ТУХАЙ

ӨМНӨХ ХУУЛИАР

Нас барсан буюу нас барсанд тооцогдсон хувь хүний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өв залгамжлагчид нь шилжинэ.
(Татварын ерөнхий хуулийн 10.3)

ИРГЭНИЙ ХУУЛЬД

Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ. (Иргэний хуулийн 515.2)



ШИНЭ ХУУЛИАР

Нас барсан болон нас барсанд тооцогдсон хувь хүний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх **өв залгамжлагчид нь өвлөсөн хөрөнгөнд ногдох хэмжээгээр шилжих** бөгөөд үүнд татварын торгууль хамаарахгүй.
(Хуулийн 14.69)

Торгуулийн үүрэг өв залгамжлагчид шилжих эсэх маргаантай асуудлыг тодорхой болгосон




ХИЛИЙН ХОРИГ ТАВИХ АСУУДЛААР

73.2. Доор дурдсан нөхцлүүд нэгэн зэрэг бий болсон тохиолдолд татварын алба татварын өртэй гадаадын иргэн, харьяалагүй хүнийг татварын өрөө төлж дуустал хилээр үл нэвтрүүлэхээр эрх бүхий байгууллагад **хандах эрхтэй**:

73.2.1. татварын өртэй этгээдэд татварын өр барагдуулах хөрөнгө, авлагагүй

73.2.2. татварын өрийн хэмжээ нь 20 сая төгрөг ба түүнээс дээш



Эрх бүхий байгууллага

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

САНГИЙН ЯАМНААС ДООРХ ЗААЛТЫГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЖ ИРГЭДИЙН САНАЛЫГ АВСАН

68.1. Татварын алба энэ хуульд заасан татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө **татварын өрийн хэмжээнээс хамаарч** татвар төлөгчид ... **зорчих эрх хязгаарлах ... арга хэмжээг авч болно.**



**АНХААРАЛ ХАНДУУЛСАН
ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА**